

9th Story

Усан дээгүүр алхсан нь

Walking on Water

Усан дээгүүр алхсан нь!

– 9th Story –



- Өгүүлэгч** Нэгэн өдөр Есүс ганцаараа залбирахаар явав. Шавь нар нь загас барихаар явчихсан байв. Хэдэн цаг загасчилахад шуурга дэгджээ.
- Бартоломай** хөөх, салхи ч ширүүн байна шүү?
- Андрей** Харин тийм, бүгдээрээ нөгөө талд нь гарцгаая. Цаг хэдийнээ оройтож, салхи улам л ширүүсэх шинжтэй.
- Петр** Есүсийг яах билээ? Залбирахаар явсан шүү дээ, бид хүлээх хэрэгтэй биш үү?
- Андрей** Есүс салсан газраа байх ёстой, тэгвэл маргааш тийшээ буцаж очицгооё.
- Өгүүлэгч** Тэд завиа аюулгүй хөдөлгөх гэж байх үед гэнэт салхи, давалгаа улам ширүүсэв. Тэр үед, яг тэр үед, Филипп усан дээр ямар нэг зүйлийг харлаа. Юу вэ, хэн бэ, юу юм бол, хэн юм бол? Тэр юу вэ, хэн бэ нь ямартай ч усан дээгүүр алхаад ирж байсан.
- Филипп** Аааааааааааа!! өө бурхан минь ээ бурхан минь өө бурхан минь !!!!
- Петр** Филипп ээ юу болоов? Юунд хашгирч бөөн юм болов? айн?
- Филипп** Аа сү сү сүнс!!!
- Петр** Юу? Филипп ээ тоглоод байлгүй тусла л даа айн? Эйн? Юу болсон бэ?
- Шавь нар** юу вэ юу вэ? Юу юм бэ? хөөх тэр юу вэ? Яаж тэгэж чадаж байна аа?
- Петр** Сая нэг хүн биднийг чиглээд усан дээгүүр алхаад ирж байсан уу? Тийм биз?
- Иуда** Хөөе, хүн угаасаа усан дээгүүр алхаж чадах уу?
- Филипп** өө, энэ бол сүнс~!!
- Өгүүлэгч** Шавь нар нь тэр хачин биет өөрсдийнх нь суусан завь руу ирж байгааг хармагцаа, бүр ухаан сөхөөгүй болчихов. Гэтэл яг тэр үед хаа нэгтээгээс их л сонсож байсан дуу хоолой сонстлоо.
- Есүс** Та нар бүү ай, энэ бол Би, Би байна
- Петр** Э э ээ Эзэн мөн гэж үү? Үнэхээр Есүс Эзэн мөн үү? Тэгвэл намайг ч гэсэн усан дээгүүр алхуулаач.



Есүс тэгэлгүй яахав, За алив хүрээд ир

Бартоломай Петр ээ, чи нээрээ хэлж байна уу? Үнэхээр алхах гэж байна уу?

Петр Эзэн минь, Би Тан руу очно, бэлн боллоо, алхаад ~~~

Есүс Маш сайн байна Петр, зөвхөн Над руу хараад ирэхэд болно.

Петр (айдас) аааа, (гайхах) Хөөх Хөөх! (бүр их айн) аааа! Багш аа, давалгаа тоглоом биш юм байна?

Есүс Петр ээ, Намайг л хар ~~~

Петр (бүр их айдаст автав) аааа~!

Есүс Петр ээ, эргэн тойрны аюултай харагдах зүйлсэд санаа тавьж болохгүй. Зөвхөн Намайг л хар. Би хамт байгаа шүү дээ.

Петр Үнэхээр аймаар, Эзэн минь, яанаа~~ би живэх нь~~ болохгүй ээ!

Өгүүлэгч Петр аймшигтай давалгаа, салхийг харангуут ус руу доошилж эхэлсэн. Харин Есүс гараа сунган Петрийг гаргалаа.

Есүс Петр ээ, итгэл чинь өчүүхэн юм. Юунд эргэлзэнэ вэ? Би хамт байна гэж хэлээгүй билүү?

Петр Уу уу уучлаарай Эзэн минь.

Есүс За завинд дээр гарцгаая.

Өгүүлэгч Петр, Есүс хоёр завинд хүрч очоод суутал шуурга намжив. Ус дөлгөөн болж тэнгэр цэлмэсэн. Есүсийн шавь нар дахин Есүсийг Бурханы Хүү гэдэг үнэнийг сэтгэлдээ сийлэв. Тэгээд магтан алдаршууллаа.

Шавь нар Үнэхээр гайхалтай~! Бидний Есүс бол Бурханы Хүү бөгөөд Эзэн. Бүр 100 хувь жинхэнэ амээн~!